

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ЖАГСААЛТ БАТЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН  
БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 06 дугаар  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Л.Энх-Амгалан**

**Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,**

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн гаргасан санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл иргэд, бизнес эрхлэгчдэд таатай орчинг бүрдүүлж, дарамт шахалтыг багасгах, тусгай зөвшөөрлийг сунгах, хуульд заасан хугацаанд зөвшөөрөл олгогдоогүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, зөвшөөрөл авахад учирдаг саад бэрхшээлийг хэрхэн багасгах, ямар ахиц дэвшил гарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр яамны сайд онцгой зөвшөөрөл олгож байгаа нь хэр оновчтой болох, мөн хуулийн төслийн 4.2-т заасан заалт нь түүхэн дурсгалт газрыг сэргээхэд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахтай хэрхэн уялдах, тусгай зөвшөөрөлгүй байгууллага хэрхэн оюутнуудыг гадаадад суралцахад зуучлах, зөвшөөрлийн зарим нэг жагсаалт нь хуулийн төслийн заалттай зөрчилдэж байгааг сайтар хянаж үзэх, адилтгах чанартай зөвшөөрлийг хэрхэн цэгцлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан зөвшөөрөл олгож байгаа байгууллага, зөвшөөрлийн тоо багасах уу, төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодод зөвшөөрлийн эрхийг хэрхэн олгох, аймгийн Засаг дарга нарт эрх мэдлийг шилжүүлэх, лицензийн задрал, үүнээс үүдэлтэй гардаг агентлагийн лиценз олгодог, эрх мэдэл бүхий албан тушаалтны бизнесийг хязгаарлах, дур мэдэн лицензийг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг зогсоох, Ерөнхий сайдын дэргэд ажиллах орон тооны бус зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнд төрийн бус мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сумьяабазар хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээд нийгмийн баялагийг бүтээгч бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдгээрт учирч байгаа дарамт шахалт, саад бэрхшээл, төрийн албан хаагчдын хүнд суртал, авлигат, зардал чирэгдлийг багасгах, төрийн ажлыг шуурхай болгох;

Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд хууль хоорондын уялдаа холбоог дахин шалгаж үзэх, тусгай зөвшөөрлийг цөөлөх, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагын саналыг авах, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, зохицуулалтгүй орон зайд үлдэхээс урьдчилан

сэргийлэх, далд зөвшөөрлийг ил болгох, бүгдийг нь хамарч чадсан эсэхийг хянаж үзэх, зөвшөөрлийн жагсаалтыг уян хатан болгох, Хөдөлмөрийн яам Мэргэжлийн боловсрол, суралтын байгууллага байгуулах зөвшөөрөл олгох нь хэр оновчтой болохыг тодруулах, ерөнхий боловсролын сургууль байгуулах болон гадаад хэлний сургалттай сургуульд тусгай зөвшөөрөл олгох зохицуулалтыг сайтар харах;

Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар зөвшөөрөл авах гарын үсгийн тоо, хүнд суртлыг багасгах, зөвшөөрлийг барьцаалах, нийтийн өмчийн эрх, тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх асуудлыг анхаарах, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг хэрхэн барагдуулах, хуулийн төслийн зарим нэг үг, үсгийн найруулгыг анхаарах;

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг жижиг бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд байгааг анхааралдаа авах, худалдаа үйлдвэрлэл эрхлэх гэрээг сунгахад учирдаг саад бэрхшээл, төрийн албан хаагчдын хүнд суртал болон мэргэжлийн хяналтын байгууллагын байцаагч нарын дарамт шахалтыг багасгах, хууль батлагдах хүртэл хугацаанд иргэдийн санал хүсэлтийг авч, зөвшөөрөл олгодог байгууллагуудтай харилцан зөвшилцөх;

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээд Хяналтын тухай хуулийн төсөлтэй хамтад нь хэлэлцэн батлах, эрх шилжүүлэх тухай эрх зүйн ойлголтыг тодорхой болгох, эрх шилжүүлэх зарчим, үндсэндээ линценз олголтыг шуурхай болгох, зөвшөөрөл авахад оршин суугаа газар болон тухайн албан тушаалтнаас хамааралгүй болгох, аж ахуйн нэгжийн лиценз хууль бус үндэслэлээр цуцлагдсанаас гарах хохирлыг барагдуулах, төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагын механизмыг тодорхой болгох зэрэг саналуудыг тус тус гаргасан болно.

### Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ

